



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 4 дугаар
сарын 28 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

“Чандмань” нийслэлийн өмчит
үйлдвэрийн газрын талаар авах
арга хэмжээний тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 87 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сонгинохайрхан дүүргийн “Чандмань” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг 2000 оны 07 сарын 20-ны өдрөөр тасалбар болгон татан буулгаж, эд хөрөнгийг ажиллагсадын хамт “Халаалтын зуухны ашиглалтын төв” нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт нэгтгэсүгэй.

2. “Чандмань” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгийг ажиллагсдын хамт “Халаалтын зуухны ашиглалтын төв” нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт хүлээлцүүлэх комиссыг дараахь бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга Гишүүд	Ц.Оюунсайхан	- Өмчийн газрын хэлтсийн дарга
	Ч.Однасан	- Өмчийн газрын мэргэжилтэн
	Д.Итгэл	- Өмчийн газрын мэргэжилтэн
	Д.Төмөрбаатар	- СХД-ийн ТСЭЗ-ийн хэлтсийн мэргэжилтэн
	Л.Балдан-Очир	- “Халаалтын зуухны ашиглалтын төв” НӨҮГ-ийн захирал
	Ч.Цэвээнжав	- “Чандмань” НӨҮГ-ийн захирал

2. Өмч хөрөнгө хүлээлцсэн тухай дүнг 8 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг Өмчийн газар /Б.Буянмөнх/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД